



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

┌ **Үндэсний бөхийн Улсын** ┐
аварга шалгаруулах тэмцээн └


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1. Үндэсний бөхийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд шалгарсан тамирчдыг Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулсугай.
- 2. Тэмцээнд оролцуулах зардалд 1,238,000 (Нэг сая хоёр зуун гучин найман мянга)-н төгрөгийг төсөвлөж, спортын тэмцээн, уралдааны зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.
- 3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Отгонсүрэн* Д.ОТГОНСҮРЭН



Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/53 тушаалын хавсралт



ТӨСӨВ

2023 оны 09 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Үндэсний бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээн

№	Спортын тэмцээний төрөл	Зардлын нэр төрөл	Жин, зай, насны ангилал тус бүрээр		Нийт үнэ
			Тоо ширхэг	Нэгж үнэ	
1	Үндэсний бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээн	Замын зардал	5	47,600	238,000
		Байр хоол- 4 хоног	5x4	50,000	1,000,000
Нийт					1,238,000